



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/638

Булган сум


Г
Хойд бүсийн залуучуудын нэгдсэн
чуулга уулзалтад оролцоход дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийн дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/026 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймагт 2025 оны 10 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулагдах Хойд бүсийн залуучуудын нэгдсэн чуулга уулзалт, сургалтын үйл ажиллагаанд оролцох төлөөлөгчдийн хоол, замын зардалд 8,000,000 (найман сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, Аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн Булган аймаг, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2025 онд хамтран ажиллах төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010888

10
A/63
Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 03-ны/ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Хойд бүсийн залуучуудын нэгдсэн чуулга уулзалтад
оролцоход шаардагдах зардал

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Сургалтын зардал	-	-	6,000,000	6,000,000
2	Автобусны түрээсийн зардал	ш	2	1,000,000	2,000,000